

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

## Итгэлцүүр хэрэглэх журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Итгэлцүүр хэрэглэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн "Журам аргачлал батлах тухай" А/64 дүгээр тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гарын үсэг

## ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцох сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид “цалин хөлс” гэх/ болон, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр шинээр тогтоолгох даатгуулагч, хүний сарын цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу дараах даатгуулагч, хүн хамаарна:

2.1.1. Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх ажил олгогч, даатгуулагч;

2.1.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн тэтгэвэр шинээр тогтоолгох даатгуулагч, хүн;

2.1.3. Нэрийн дансны гарааны үлдэгдэлтэй даатгуулагч;

2.1.4. Цэргийн алба хаагч.

### Гурав. Итгэлцүүр хэрэглэх

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл /цаашид “шимтгэл” гэх/-ийг нөхөн төлүүлэх цалин хөлсний хэмжээг Засгийн газраас тогтоосон итгэлцүүрээр өсгөн доор дурдсанаар тооцно:

3.1.1. Ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийг нөхөн төлүүлэхэд баримтлах сарын цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн, тухайн цалин хөлсийг олгосон хугацаанд мөрдсөн ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон нөхөн төлөх шимтгэлийн хэмжээг тогтооно.

3.1.2. Ажил олгогчийн шимтгэл нөхөн ногдуулах итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь тухайн ажил олгогчийн сарын нийт цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлоготой тэнцүү байна.

3.1.3. Албан журмын даатгуулагчийн шимтгэл нөхөн ногдуулах итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох,

тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 404 000 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөг, мөн өдрөөс хойших хугацаанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

3.1.4.Сайн дураар даатгуулагчийн шимтгэл нөхөн ногдуулах итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 1 404 000 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөг, мөн өдрөөс хойших хугацаанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 7 дахин нэмэгдүүлсэнтэй (4 620 000 төгрөг) тэнцүү байна.

3.1.5.Цэргийн жинхэнэ алба хаагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг тухайн алба хаагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш авсан сар бүрийн цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэж, шимтгэл төлөх үеийн ажил олгогчийн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон төлөх шимтгэлийн хэмжээг тогтоон тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс тухай бүр төлнө.

3.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход даатгуулагч хүн, цэргийн албан хаагчийн тэтгэвэр бодох сарын цалин хөлсөнд итгэлцүүрийг дараах байдлаар хэрэглэнэ:

3.2.1 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг бодох сар бүрийн цалин хөлсийг тухайн оны итгэлцүүрээр өсгөн тооцно.

3.2.2.Тэтгэвэр бодох сарын дундаж цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн тооцоход энэ журмын 3.1.3 заасан дээд хэмжээг баримтална.

3.2.3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу 1995-2019 оны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн хугацааны хөдөлмөрийн хөлс (420.000 төгрөг)-нд Засгийн газраас тогтоосон итгэлцүүрийг хэрэглэхгүй.

3.3. Засгийн газраас тогтоосон итгэлцүүр нь 2024 онд Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр”, 2025 оноос хойших хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22.2-д заасны дагуу өмнөх оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө баталсан итгэлцүүр байна.

3.4. 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2000 оны 01 дүгээр сарыг 01-ний өдрөөс өмнө төлсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцохдоо 1995-1999 оны сар бүрийн цалинд нэрийн дансны итгэлцүүр хэрэглэнэ.

3.4.1. Нэрийн дансны 1995-1999 оны итгэлцүүр:

№	Он	Нэрийн дансны итгэлцүүр
1	1995	10.06
2	1996	4.60
3	1997	3.83
4	1998	3.54
5	1999	3.22

3.6.Нийгмийн даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн жинхэнэ алба хаагчийн 1995 оноос өмнөх алба хаасан хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг цэргийн алба хаагчийн сар бүрийн цалин хөлсийг тухайн оны итгэлцүүрээр өсгөсөн дүнгээс нэрийн дансны орлого бүртгэх үед мөрдөж байгаа ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

4.2.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

— оОо —